



The AMERICAN CHAMBER of Commerce in Mongolia

e-journal AMCHAM CSR

2025 оны 1-р улирал
Дугаар №16

I'VE JUST GIVEN SOMEONE AN AMAZING GIFT

#GiveBlood ONE MSM

ХАМТЛА 35-37

ЦОХИЛОХ СУРХ БҮХНИЙГ АВАХ

#ONE MSM

Barloworld Mongolia CAT

CAPITRON BANK

MSM

Өмнөх үг

Бид "АмЧам Монгол"-ын нийгмийн хариуцлагын хүрээнд гаргадаг электроник сэтгүүлийнхээ 16 дахь дугаарыг өргөн барьж байгаадаа баяртай байна.

Манай сэтгүүл дээр гарч буй эдгээр нийтлэлүүд манай гишүүдийн Компанийн Нийгмийн Хариуцлагын (CSR) олон үйлсэд оруулж буй үр шимийг онцлон тэмдэглэхээс гадна, Байгаль орчин, Нийгэм, Засаглалын (ESG) зарчмыг ямагт дээдлэн, хамтын хөгжилд үнэнч хэвээр байгаатай та бүхэн санал нэг байх биз ээ.

Хүн бүхний тогтвортой ирээдүйг бий болгоход тууштай зүтгэж, манлайлж байгаа гишүүддээ гүн талархал илэрхийлье.

Ажлын тайлан, явцаа хуваалцсан нийт гишүүддээ баярлалаа!

Хүндэтгэсэн,
Л. Эрдэнэбилэг

Хэвлэл мэдээлэл, олон нийт хариуцсан захирал | Редактор
АмЧам Монгол



Barloworld
Mongolia



Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн тохижилт

Хүчирхийллийн эсрэг үндэсний төв нь 1995 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд эмэгтэйчүүдэд түр хамгаалах байрны үйлчилгээг үзүүлдэг цор ганц төрийн бүс байгууллага юм.

Жилд дунджаар 120-150 үйлчлүүлэгч тус хамгаалах байраар үйлчлүүлдэг бөгөөд 1-3 сарын хугацаанд байрлуулан хамгаалах үйлчилгээ үзүүлдэг.




Тус хамгаалах байранд байрлах хугацаанд нь эмэгтэйчүүдэд зориулсан мэргэжлийн чиг баримжаа олгох гар урлал, оёдол эсгүүрийн сургалтаар хангах, сургуулийн насны хүүхдүүдийг сургууль завсардахаас сэргийлэн тогтмол сургуульд хамруулах үйлчилгээг давхар явуулдаг.

Барловорлд Монголиа компанийн хөрөнгө оруулалтын хорооноос тус төвийн хамгаалах байрны дотоод тохижилт

болон засварыг хийж гүйцэтгэх ажилд нийтдээ 30 гаран сая төгрөгийг зарцуулсан бөгөөд хүүхдийн нэг өрөө, унтлагын 2 өрөө, гал тогоо болон коридор нийт 5 өрөөнд засвар хийсэн.

Мөн хамгаалах байраар үйлчлүүлж байгаа хүүхэд эмэгтэйчүүдэд зориулсан ариун цэврийн хэрэгслийн 1 сая төгрөгийн багцыг ажилчдын хандив тусламжаар цуглуулан хүргүүлсэн.



Өмнө



Өмнө



Өмнө



Дараа



Дараа



Дараа

Боловсролын салбарын тэгш бүс байдлыг бууруулж, хүүхэд бүрд өөрийн хүссэн ирээдүйгээ бүтээх боломжийг бүрдүүлэх их үйлсийг бид дэмждэг



“Teach For Mongolia” буюу “Илгээлтийн Багш” НҮТББ нь Дэлхийн 60 гаруй оронд салбартай “Teach for All” олон улсын байгууллагын албан ёсны гишүүн бөгөөд Монгол Улсад бүртгэлтэй ашгийн төлөө бүс байгууллага юм.

“Teach for Mongolia” нь хэрэгжүүлжбуйхөтөлбөрийн

хүрээнд нийгэмд эерэг өөрчлөлт авч ирэх чин эрмэлзэлтэй, дотоодын болон гадаадын шилдэг их, дээд сургууль төгссөн залуу манлайлагчдыг сонгон шалгаруулж багшийн орон тооны дутагдалтай хөдөө орон нутгуудад хоёр жилийн хугацаанд үндсэн багшаар ажиллуулдаг.

Илгээлтийн багш нар тухайн томилогдон очсон орон нутгийнхүүхэд, эцэгхүүхдэд эерэг нөлөөлөл үзүүлж, боловсролын хүртээмжийг сайжруулах, сурагчдад хөгжих боломжуудыг нээх, хүүхэд бүр өөрийн хүссэн ирээдүйгээ бүтээх боломжийг бүрдүүлэхийн төлөө ажилладаг.

Барловорлд Монголиа ХХК-ийн Нийгмийн Хөрөнгө Оруулалтын Хороо нь “Орон нутгийн сургуулийн удирдлагыг чадавхжуулах хөтөлбөрт дэмжлэг үзүүлж байгаа ба орон нутаг дахь боловсролын хүртээмжтэй

байдлыг нэмэгдүүлэх тэдний их үйлсэд ихээхэн тус нэмэр болж байгаа гэдгийг дуулгахад таатай байна.

Энэ жил 6 аймаг, 9 сумын 30 орчим удирдлагыг Улаанбаатар хотноо

цуглуулан 3 өдрийн эрчимтэй сургалтаа эхлүүлж байна. Энэхүү хөтөлбөр нь 2 сарын 19 өдрөөс эхлэн ирэх 11 сар хүртэл цахим болон танхимын хосолсон байдлаар зохион байгуулагдах юм.



Шинэ жилийг өөр нэгэн утга учиртай үйлсээр угтлаа!



Барловорлд Монголиа компанийн Нийгмийн хөрөнгө оруулалтын хорооноос UB Shelter-Амьтан асрах төвд тус бүр нь хорин тонн жинтэй хоёр чингэлэг хандивлалаа. Энэхүү

хандив нь тус байгууллагын амьтан аврах үйл ажиллагааг сайжруулах, амьтдыг дулаан таатай орчинд амьдрахад чухал ач холбогдолтой юм.

UB Shelter-Амьтан асрах төвийнхөн “Бидэн шиг ийш тийшээ нүүдэл суудал их газарт хамгийн тохиромжтой сууц бол яалт ч үгүй контейнер санагдсан. Олон амьтныг амьдрах гэрээр хангаж байгаа танай байгууллага бол жинхэнэ энэрэнгүй үйлстнүүд” хэмээн талархлаа бидэнд илэрхийлсэн юм.

UB Shelter-Амьтан асрах төв нь 2017 онд үүсгэн байгуулагдсан ашгийн бус байгууллага бөгөөд гудамжны тодотголтой эзэнгүй золбин амьтдыг аварч, хайр халамж үзүүлэх, тохитой орчинд байршуулах зорилготой. Өнгөрсөн долоон жилийн хугацаанд Налайх дүүргийн нутаг дэвсгэрт байрлах тус байр нь хоёр зуу гаруй эзэнгүй амьтдыг авран хамгаалж, ная гаруйг нь амьтан тэжээх, үрчлэн авах хүсэлтэй иргэдэд өгсөн ба энэ нь асар их амьтдын амийг аврахад хувь нэмэр оруулсан.

Хог хаягдлыг бууруулж тогтвортой байдлыг нэмэгдүүлэх нь

Барловорлд Монголиа ESG-ийн хүрээнд хэрэгжүүлж буй санаачилгынхаа хүрээнд саяхан 200 гаруй ширээний хогийн савыг устгаснаар тогтвортой байдлын чиглэлд чухал алхам хийлээ.

Оффисын өрөө, тасалгаа бүрд байдаг олон хогийн савны оронд компани хог хаягдлын төвлөрсөн цэгүүдийг ажиллуулж,

коридорын давхар бүрд гурван том хогийн сав байрлуулжээ. Эдгээр хогийн савнууд нь: а) дахин боловсруулах хуванцар, хөнгөн цагаан, б) цаас, в) нийтлэг хог хаягдлаар зориулагдсан. Бид энэхүү санаачилгаар дамжуулан 2024 оны сүүлийн улиралд 2023 оны мөн үетэй харьцуулахад хогийн цэгт илгээсэн нийтлэг хог хаягдлыг 20 хувиар бууруулж чадсан.



Капитрон банкны нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд

Тайлант хугацаа: 2025 оны нэгдүгээр улирал
Капитрон банк нь үүсэн байгуулагдсан цагаасаа эхлэн Монгол Улсын банк, санхүүгийн системд тогтвортой өсөлттэй ажиллаж, банкны санхүүгийн үзүүлэлтүүд жил бүр тогтмол өсч, банкны системд эзлэх байр сууриа улам бэхжүүлсээр байна.

Түүнчлэн банк нь нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд нийгэм, эдийн засгийн тэргүүлэх ач холбогдолтой төсөл, хөтөлбөрүүд, соёл урлаг, спортын олон үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллаж,

ёс зүйтэй, хариуцлагатай аж ахуйн нэгжийн үүргээ биелүүлсээр ирлээ.

Хүрээлэн буй орчинд ээлтэй, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилготой ногоон зээл, бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээл гэх мэт бүтээгдэхүүнийг харилцагчдадаа санал болгодог.

Тайлант 2025 оны нэгдүгээр улиралд Капитрон банкны компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд хийж, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн мэдээллийг хүргэж байна.



КАПИТРОН БАНК, МОНГОЛЫН МАТЕМАТИКИЙН ОЛИМПИАДЫН ХОРООТОЙ

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА



- “Монголын математикийн олимпиадын хороо” хамтын ажиллагаа

Капитрон банк нь боловсролын салбарт тэр дундаа математикийн шинжлэх ухаанд хөрөнгө оруулалт хийхээр Монголын Математикийн Олимпиадын Хороотой хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан.

Энэхүү санамж бичгийн хүрээнд ЕБС-ийн сурагчдад математикийн шинжлэх ухааныг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх, хөгжүүлэх, цаашлаад олон улсад өрсөлдөхүйц түвшний боловсрол, үр чадвартай мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэхэд хамтран ажиллаж байна.

Хамтын ажиллагааны хүрээнд Европын охидын Математикийн 14-р Олимпиадад эх орноо төлөөлөн оролцох сурагчдыг шалгаруулах сорилгын нэг, хоёрдугаар үеийг амжилттай зохион байгуулаад байна.

- “Junior Internship Program 2025” хөтөлбөр

Монголын банк, санхүүгийн салбарын зургаа дахь том банк Капитрон банк нь эх орны ирээдүй болсон хүүхэд, залуусын боловсролыг дэмжих зорилгоор Зориг сангаас жил бүр хэрэгжүүлдэг Залуу Дадлагажигч хөтөлбөрийг хоёр дахь жилдээ дэмжин хамтран ажиллаж байна.

Боловсрол бол тогтвортой хөгжил, гэрэлт ирээдүйн гол тулгуур учраас Капитрон банкнаас энэхүү хөтөлбөрийг хоёр дахь жилдээ дэмжин ажиллаж байгаа билээ.

Өмнөх жилийн хөтөлбөрт шалгарсан оролцогчид Капитрон банкнаас дээр ирж, банкны бүтэц, үйл ажиллагаа, газар, хэлтсүүдийн ажлын чиг үүрэг болон банкируудын ажлын онцлогтой танилцаж байсан билээ.

Монцемент Билдинг Материалс ХХК “Таблеттай багш” санаачилгын дэмжигч байгууллагаар ажиллаж байна



Монцемент Билдинг Материалс ХХК нь Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар болон НҮБ-ын Хүүхдийн сангийн хамтран хэрэгжүүлж буй “Таблеттай багш” санаачилгыг компанийнхаа нийгмийн хариуцлагын хүрээнд Дорноговь аймагт дэмжин ажиллаж байна.

Тус хөтөлбөр нь хөдөө орон нутгийн малчдын 2-5 насны 600 гаруй хүүхэд болон тэдний эцэг эх, асран хамгаалагчдад хүртээмжтэй, чанартай сургалт авах боломжийг бий болгох зорилготой юм.

Монцемент Билдинг Материалс ХХК нь Монполимет групп болон Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны хөрөнгө оруулалтай байгуулагдсан, үндэсний бүтээн байгуулагч компани юм.

Дорноговь аймгийн Өргөн суманд үйл ажиллагаа явуулдаг Монцемент үйлдвэр



Энэхүү ажлын хүрээнд Дорноговь аймгийн **35 ЦЭЦЭРЛЭГИЙН БАГШ НАРТ** бага насны хүүхдийн боловсролыг дэмжих таблет суурьтай ухаалаг сургалтын иж бүрдлийг албан ёсоор хүлээлгэн өглөө.



нь 1 сая тонн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай ба байгаль орчинд ээлтэй, орчин үеийн хуурай аргын технологийг ашиглан өндөр чанарын цемент үйлдвэрлэж Монгол Улсын барилгын салбарт нийлүүлдэг.

Монцемент нь нийгмийн хариуцлагын хүрээнд боловсрол, байгаль орчин, орон нутгийн хөгжлийн төслүүд, санаачилгыг Дорноговь аймаг орон нутагт дэмжин ажилладаг.



MSM групп Ид Шидийн Орон Хэнтий салбарт техник спортын сургалтын гар багаж хэрэгслийг хандивлалаа

MSM Группээс компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд Ид Шидийн Орон Хэнтий хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийн техник спортын сургалт дугуйланд шаардлагатай гар багаж хэрэгслийг хандивлалаа.

Ид Шидийн Орон Хэнтий хүүхэд хамгаалал, хөгжлийн төв нь хүүхдүүдийн инженер, техник сэтгэлгээг хөгжүүлэх, шинжлэх ухааны мэдлэг хүргэх, технологийн боловсрол олгох зорилгоор техник спортын сургалтыг үнэ

төлбөргүйгээр хүүхдүүдэд хүргэдэг юм. Техник спортын сургалтаар нисэх загвар, усан загвар, авто загвар болон оньсон техник зэрэг загваруудыг зохион бүтээх инженерийн мэдлэг чадвар, ур дүйд хүүхдүүд суралцаж бүтээдэг байна.

MSM Группээс суралцагч бүрийн оролцоо, хүртээмж болон бүтээмжийг сайжруулах зорилгоор сургалтад шаардлагатай багаж хэрэгслийг хандивлаж байгаа юм.



МСМ группийн хамт олон цусаа хандивлалаа

МСМ Групп ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд Цус сэлбэлт судлалын үндэсний төв (ЦССҮТ)-тэй хамтран цус хандивлах үйл ажиллагааг амжилттай зохион байгууллаа.

Энэхүү хүмүүнлэгийн үйлсэд манай 60 гаруй ажилтан оролцож, цусаа хандивлан донорын

эгнээнд нэгдсэн бөгөөд цугласан цус, цусан бүтээгдэхүүн нь 190 гаруй хүнд шаардлагатай сийвэн, улаан эс, ялтаст цусан бүтээгдэхүүн болж хүрэх боломжтой боллоо.



234 Кг = 17,000 хуванцар сав, лааз

Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд МСМ Групп нь хог хаягдлыг багасгах, дахин боловсруулах ажлыг тогтмол хэрэгжүүлдэг билээ. Бид компанийн үйл ажиллагаанаас гарсан хаягдлыг байгальд сөрөг нөлөөгүйгээр боловсруулж, дахин боловсруулах компаниудад нийлүүлдэг.

2024 онд бид 234кг хуванцар, лааз, 75кг электрон хаягдал, 24,9тн хаягдал тос, 9,6тн

химийн бодисын уут, шуудай, 40,2тн хаягдал химийн бодис болон бусад хог хаягдлуудыг дахин боловсруулах компаниудад нийлүүллээ.

МСМ Групп нь компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, хүүхдийн боловсрол зэрэг чиглэлүүдээр нийгмийн сайн сайхан, хөгжилд урт хугацааны бодит хувь нэмэр оруулж буй төсөл, хөтөлбөрүүдийг дэмжин ажилладаг.



#ONE MSM



Бусад хог

154.5тн



Хуванцар

153кг



Лааз

81кг



Электрон хаягдал,
батарей

75кг



Хаягдал тос

24.9тн



Химийн бодисын
төмөр торх

113ш



Химийн бодисын
хуванцар сав

38ш



IBC танк

272ш



Химийн бодисын
уут шуудай

9.6тн



Хаягдал
химийн бодис

40.2тн



Хаягдал
аккумулятор

8ш

2024 онд

компанийн үйл ажиллагаанаас гарах энгийн болон үйлдвэрлэлийн тусгай хаягдлыг төрлөөр ангилан дахин боловсруулах компаниудад нийлүүллээ.

